



УНТЭ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.БЯМБАДОРЖ

БАТЛАВ:



ЦССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОНД ХЭРЭГЛЭХ
ЦАХИЛГААН, ДУЛААН, ЦЭВЭР, БОХИР УС, ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН УСНЫ
ХАНГАМЖИЙН ГЭРЭЭ**

2016 оны 01 сарын 04-ний өдөр

№ Унтэ 13/16

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас ЦССҮТ /цаашид хэрэглэгч тал гэх/ түүнийг төлөөлж Нөөц, хангамж үйлчилгээний тасгийн эрхлэгч Ч.Далайцэрэн нөгөө талаас “Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг /цаашид Нийлүүлэгч тал гэх/ түүнийг төлөөлж Стратеги төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Д.Далайжаргал хамтад нь /талууд гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид гэрээ гэх/ байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн хэрэгцээт дулаан, цэвэр, бохир ус, хэрэглээний халуун усны хангамж /цаашид үйлчилгээ гэх/-ийг Хэрэглэгчтэй тохиролцсон хугацаанд тогтвортой нийлүүлэх, Хэрэглэгч нь Нийлүүлэгч талд үзүүлсэн үйлчилгээний үнийг тарифын дагуу төлөх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын иргэний хууль, түүнд нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Гэрээ нь 1 хавсралттай бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна. Хавсралт № 1 – Хэрэглэгчид шаардлагатай үйлчилгээний нэр, нэр төрөл, хэмжих нэгж, сар жилийн хэрэгцээ, үнэ тарифын тусгана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ГОЛ ЗҮЙЛ

2.1 Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн захиалгын дагуу түүнд шаардлагатай хавсралт №1-д заасан нэр төрлийн үйлчилгээг үзүүлнэ.

- 2.2 . Гэрээний үйлчлэх хугацаа 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байна.
- 2.3. ЦССҮТ –ийн шинэ барилга ашиглалтанд орсон үед гэрээг шинэчлэн ЦССҮТ-ийн II байр, Эмгэг судлалын үндэсний төвийн ашиглалтын гэрээг тусад нь байгуулна.
- 2.4. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр тохиролцож сунгаж болно.
- 2.5. Гэрээний үйлчлэх хугацааг дараахь тохиолдолд зогсоож болно:
- Талуудын зөвшилцсөнөөр;
 - Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр;
 - Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 3.1. Хэрэглэгч /ЦССҮТ/-ийн инженер сар бүрийн 17-ны дотор Нийлүүлэгчээс цахилгааны тоолуурын заалт авах, хянах
- 3.2. Халаалт дулааны зардлыг мөрдөгдөж буй тарифын дагуу Хэрэглэгчийн талбайн хэмжээнд ногдуулан тогтмол тооцно.
- 3.3. Гэрээний хавсралтад заасны дагуу дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, хэрэглээний халуун усны төлбөрийн нэхэмжлэлийг Хэрэглэгч талд ирүүлнэ.
- 3.4. Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэлийн хоногт багтаан шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ.

- 4.1. Нийлүүлэгч тал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
- 4.1.1. Дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, халуун усны хангамжийн найдвартай байдлыг хариуцан ажиллана.
 - 4.1.2. Дулаан, цахилгаан, цэвэр бохир усны хоолой системд гарсан гэмтэлд мэргэжлийн туслалцаа үзүүлж, засвар үйлчилгээний хөлсийг тухай бүрт тооцож гүйцэтгэнэ.
 - 4.1.3 Улсын хэмжээнд мөрдөгдөж буй үнэ тарифын өөрчлөлтийн дагуу гэрээнд тодотголыг тухай бүрт нь хийх
 - 4.1.4 ЦШС, ДШС, ЦСУТ эдгээр байгууллагуудаас мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу хугацаанд төлөгдөхгүй байгаа цахилгаан дулааны хөлсийг төлөөгүй үед торгуулийн хувь ногдуулж ажиллах

4.2. Хэрэглэгч тал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.2.1. Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу дулаан цахилгаан, цэвэр, бохир, халуун усны төлбөрийг тухайн сарын 30-ны дотор /нэхэмжлэлийн хугацаа/-д төлөх

4.2.2. Хэрэглэгч нь цахилгаан, дулаан, цэвэр, бохир, халуун ус шугам тоноглолд гарсан, материалын зардал, засвар ажил үйлчилгээний хөлсийг хариуцана.

4.2.3. Дулаан, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугамын заалтыг Нийлүүлэгч /УНТЭ/-ийн төв узелиэс байрлуулсан өөрийн хэрэглэгчийн шугам тоноглолыг бүрэн хариуцана.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

5.2 Хэрэглэгч тал гэрээнд заасан хугацаандаа хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1%-н алдангийг Нийлүүлэгч талд төлнө.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 8.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.3. Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Хэрэглэгч тал 1 хувь, Нийлүүлэгч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хэрэглэгч талыг төлөөлж:

ЦССҮТ-ийн Нөөц Хангамж

Үйлчилгээний Тасгийн эрхлэгч

...../Ч.Далайцэрэн/

Стратеги төлөвлөлт хариуцсан
ажилтан

...../Ч.Батболд/

Тооцооны нягтлан бодогч

...../Ц.Гадинжид/

Утас: 976-11-312857

Э-шуудан: nctmmgl@gmail.com

Хаяг: Улаанбаатар хот Энхтайваны

Нийлүүлэгч талыг төлөөлж:

УНТЭ-ийн Стратеги төлөвлөлт

эрхэлсэн дэд захирал

...../Д.Далайжаргал/

Инженер АТТ026

...../Г.Цэрэнбадам/

Нягтлан бодогч

...../Н.Урансүрэн/

Утас: 976-11-323857

Хаяг: Улаанбаатар хот СБД-ийн 1-р

хороо С.Зоригийн гудамж-2

Данс:

Регистер:

ЦССҮТ-ИЙН 2016 ОНД ХЭРЭГЛЭХ
ЦАХИЛГААН, ДУЛААН, ЦЭВЭР, БОХИР УС,
ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН УСНЫ ХАНГАМЖИЙН
2016 ОНЫ 01 САРЫН 04-НИЙ ӨДРИЙН
№ ... ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

ЦССҮТ-ийн 2016 оны зардлын тооцоо

Зардлын дүн	Хэмжих нэгж	Сарын хэрэглээ	Нэг бүрийн үнэ	Ашиглалтын сар	Сард төлөх	Төлбөрийн нийт дүн /төг/
Дулаан	М ³	5610	472	8	2,647,920	21,183,360
Халуун ус	Гкал/ц	628.56	500-6894	12	250,000	3,000,000
Цэвэр ус	М ³	500	910	12	455,000	5,460,000
Бохир ус	М ³	500	600	12	300,000	3,600,000
Цахилгаан	квт	-	141.35	12	Тоолуурын заалтаар	Тоолуурын заалтаар

Судалгаа гаргасан НХҮТ-ийн Инженер: Э.Дашзэвэг Э.Дашзэвэг